

“АВТО ҮЙЛЧИЛГЭЭ- ЕРӨНХИЙ ШААРДЛАГА, АНГИЛАЛ” MNS5025:2010**1. Зорилго**

Энэхүү стандартын зорилго нь авто үйлчилгээг зохион байгуулах нийтлэг шаардлага, журам тогтооход төр, захиргааны болон бусад байгууллагаас хяналт тавих, авто засварын бүтээгдэхүүн, үйлчилгээнд чанарын баталгаат тогтолцоо бий болгох, ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандарт нь авто засварын үйлчилгээ эрхлэгч байгууллага /Хөдөлгүүр, хүч дамжуулах ангийн засвар, авто машины их бие засвар, дугуй засвар, тос тосолгооны газар/ажил үйлчилгээнд тавих шаардлагыг тогтооход хамаарна. Энэхүү стандартыг авто засвар эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөнө.

Авто зогсоолын газар MNS5342-2007, авто угаалгын газар MNS5347-2003 стандартыг мөрдөн ажиллана.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартыг боловсруулахад ашигласан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- MNS4601:98, Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн, техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо, тодорхойлолт
- MNS4598, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага
- MNS5011, Автотээврийн хэрэгслийн техникийн байдлын үзлэг хийх заавар, ерөнхий шаардлага
- MNS5013:2009, Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
- MNS5014:2009, Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
- MNS5044:2010, Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв-Ангилал. Ерөнхий шаардлага
- MNS5342:2007, Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага
- БНБД31-03-03, Олон нийт, иргэний барилгын норматив, дүрэм
- БНБД32-04-06, Хот суурины гудамж талбайн төлөвлөлтийн норматив, дүрэм
- MNS5021:2007, Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага
- MNS6595:2016, Автотээврийн салбарын ажил мэргэжлийн стандарт-Ерөнхий шаардлага
- MNS3850:1985, Техникийн үйлчилгээ засварын систем. Нэр томъёоны тодорхойлолт

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1 Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

4.1.1 Авто үйлчилгээ

Автотээврийн хэрэгслийн техникийн байдлыг оношлох, техникийн үйлчилгээ, засвар хийх, хадгалах, тосолгооны болон ашиглалтын бусад материал худалдах, цэнэглэх, сэлбэг хэрэгсэл, худалдах зэрэг автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйл ажиллагаа;

4.1.2 Авто үйлчилгээний байгууллага

Автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

4.1.3 Хөдөлгүүр, хүч дамжуулах ангийн засвар

Техник ба эдлэхүүнийг бүхэлд нь эсвэл түүнийг бүрдүүлэх хэсгийн ажиллах чадвар, мөн гэмтэл согоггүй байдлыг сэргээхэд чиглэсэн цогцолбор ажил, ажилбаруудыг гүйцэтгэх газрыг;

4.1.4 Авто машины их бие засвар

Автомашинны их биеийн эвдрэл гэмтлийг сэргээн засварлахтай холбогдуулан хийх бүхий л ажилбарыг гүйцэтгэх газрыг;

4.1.5 Дугуй засвар

Автомашинны дугуйг зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглан тайлах, задлах, нөхөх, хийлэх, шалгах, угсрах, тэнцвэржүүлэх, солих ажилбарыг гүйцэтгэх газар;

4.1.6 Тос тосолгооны газар

Тос, тусгай шингэн зэрэг ашиглалтын материалаар цэнэглэх, цэвэрлэгээ хийх, агрегатын байдал, иж бүрдлийг шалгах, оношлох, чангалах, тослох, тохируулах ажлыг тогтоосон үечлэлийн дотор хийгдэх цогцолбор үйлчилгээний газрыг;

4.1.7 Технологи

Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц;

4.1.8 Технологи ажиллагаа

Аливаа ажил, үйлчилгээний ажилбарыг техникийн нөхцлийн дагуу гүйцэтгэх тогтоосон дараалал;

4.1.9 Ажилбар

Автомашинны аль нэг агрегат, зангилаа, системийн засвар, үйлчилгээг гүйцэтгэх дэс дараалсан үйлдлийн цогц;

4.1.10 Технологийн карт

Авто үйлчилгээний технологи ажиллагаанд тулгуурласан тухайн авто үйлчилгээний ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилбар, шилжвэр, үйлдлийн дараалалд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажлын зэрэг, хугацааг нэг бүрчлэн хүснэгтлэн жагсаасан, шаардлагатай тохиолдолд схемчлэн үзүүлсэн техникийн баримт бичиг;

4.1.11 Мэдээллийн сан

Авто үйлчилгээний байгууллага, иргэдийн хаяг байршил, хүний нөөц, үйлчилгээний онцлог, үйлчилгээний үнэ тариф, ажиллах цагийн хуваарь, үзүүлсэн үйлчилгээний талаарх өгөгдлүүдийг цаашид өргөтгөх боломжтойгоор үүсгэсэн өгөгдөл бааз;

4.1.12 Засвар үйлчилгээний ажлын дэвтэр

Тухайн тээврийн хэрэгсэлд хийсэн засвар үйлчилгээ, түүний цаг хугацаа болон засварын баталгааг хөтөлсөн дэвтэр;

4.1.13 Ажлын байр

Ажилчин хүн тодорхой ажилбарыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай технологийн тоног төхөөрөмж, багаж, нэмэлт хэрэгслээр тоногдсон ажиллах орчин;

4.1.14 Мэргэжил

Тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардах мэдлэг, чадвар, дадлын цогц

4.1.15 Мэргэжлийн боловсрол

Тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшил

5. Авто үйлчилгээний байгууллагад тавигдах ерөнхий шаардлага

5.1 Нутаг дэвсгэрийнхээ бүртгэх байгууллагад тогтоосон журмын дагуу бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан , эрхлэх ажил, үйлчилгээний нэр төрөл, үйл ажиллагааг тодорхой заасан байх;

5.2 Үйлдвэрлэл, үйлчилгээний газар нь өөрийн нэр, ажиллах цагийн хуваарь, холбогдох утасны дугаар бүхий самбарыг монгол хэл дээр бичиж харагдахуйц газар байршуулж, бүтээгдэхүүн, засвар үйлчилгээний үнийг нэг бүрчлэн үнэн зөв, ил тод бичсэн байх;

5.3 Эрхлэх ажил үйлчилгээ нь хүрээлэн байгаа орчин, оршин суугчдад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй, галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, хөдөлмөрийн эрүүл ахуй, тав тухтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн байх;

5.4 Техникийн аюулгүй ажиллагаа, үйлчилгээний соёл, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар, журам тогтоож мөрдүүлсэн байх;

5.5 Авто үйлчилгээ эрхлэгч нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламж, зогсоол талбай, технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байх;

5.6 Хөдөлгүүр, хүч дамжуулах ангийн засварын газар нь эрх бүхий байгууллагаар хөдөлмөрийн нөхцлийн болон эрсдлийн үнэлгээг тус тус хийлгэсэн байх;

5.7 Автомашины их бие засварын газар нь будаг хийлгэсэн машиныг +40°C халуун хатаах зориулалтын будгийн бүхээгтэй, тоосгүйжүүлэх усан хөшиг эсвэл тоосгүйжүүлэх төхөөрөмжтэй байх;

5.8 Автомашины их бие засварын газар нь гэмтэлтэй автомашиныг засварын ажилд хүлээн авч, хүлээлгэн өгөх хуудсанд мава автомашин эзэмшигчид автомашины явалт, автомашины явах анги, их биеийн зурагнуудыг өгч тээврийн хэрэгслийг хүлээн авах.

6. Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжид тавих нийтлэг шаардлага

6.1 Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж түүний инженерийн шугам сүлжээ нь авто үйлчилгээний үйлдвэрлэл,

үйлчилгээг явуулахад зайлшгүй шаардлагатай БНБД31-03-03 “Олон нийт, иргэний барилга”, БНБД32-04-06 “Хот суурины гудамж талбайн төлөвлөлт”-д заасан норматив шаардлагыг хангасан хөдөлгүүрийн ажилласан хийг зайлуулах, агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.

6.2 Галын аюулгүйн шаардлагыг бүрэн хангаж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу, цэвэр, бохир усны системд холбогдсон эсвэл тусгай байгууламжтай байна.

7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавигдах нийтлэг шаардлага

7.1 Тодорхой таних тэмдэг бүхий хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан зориулалтын өвөл, зуны улиралд тохирсон ажлын хувцас өмсөж, засвар үйлчилгээ үзүүлнэ.

7.2 Авто засварын газар нь яаралтай тусламж үзүүлэх иж бүрдэл болон галын аюулгүй ажиллагаанд шаардагдах багаж хэрэгслээр хүрэлцэхүйц хангагдсан байна.

7.3 Эрхлэх ажил үйлчилгээ нь хүрээлэн байгаа орчин, оршин суугчдад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй, галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, хөдөлмөрийн эрүүл ахуй, тав тухтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн байх;

7.4 Техникийн аюулгүй ажиллагаа, үйлчилгээний соёл, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар, журам тогтоож мөрдүүлсэн байх;

7.5 Хангалттай ажиллах агаар бүхий тусгай өрөө тасалгаанд компрессорыг байрлуулдаг байх;

7.6 Ажлын байранд хийгдэх техникийн оношлогоо, үйлчилгээ, засварын ажлын төрөл бүрээр ажлын дэс дарааллыг тогтоосон технологийн карт, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглалтын аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж, ажлын байранд байрлуулж, мөрдүүлэх;

7.7 Автомашины их биеийн засварчин нь их биеийг будах ажилбарыг гүйцэтгэх үедээ химийн хорт бодисоос хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

8 Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавигдах нийтлэг шаардлага

8.1 Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байхаас гадна өргөж тээвэрлэх, хэмжих, хянах багаж хэрэгсэл, өндөр даралтанд ажиллах тоноглол зэрэг нь тогтоосон журмын дагуу эрх бүхий байгууллагаар шалгаж баталгаажуулсан байна.

8.2 Суурин ба зөөврийн тоноглол нэг бүрт техник ашиглалтын бүртгэлийн дэвтэр хөтөлж, аюулгүй ажиллагааны заавартай байна.

8.3 Хөдөлгүүр, хүч дамжуулах ангийн засварын газар нь олон суваг, өргүүртэй бол түүний тоогоор ашиглагдах багаж тоног төхөөрөмжтэй байж, тус бүрт утаа зайлуулах төхөөрөмжтэй байна.

8.4 Гагнуур хийх зориулалтын багажтай байна.

8.5 Тос тосолгооны газар нь ажилласан тосыг хураах, хадгалах тусгай савтай байна.

8.6 Засвар, үйлчилгээний газар нь өргүүр болон суваг эсвэл аль алинтай нь байна.

9. Хүний нөөцөд тавих нийтлэг шаардлага

- 9.1 Авто засвар, үйлчилгээний газрын удирдах албан тушаалтан эсвэл өдөр тутмын ажлыг зохион байгуулагч нь автотээврийн дээд боловсролтой, эрхэлсэн ажлынхаа чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан мэргэшсэн инженер байна.
- 9.2 Авто засвар, үйлчилгээний газрын инженер нь механик инженерийн мэргэжилтэй, механик нь автотээврийн хэрэгслийн бүх төрлийн хийц загварыг оношлогооны тоног төхөөрөмж, ашиглан оношлох, засварлах техникч-механикч мэргэжилтэй, засварчин нь засвар үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн эзэмшсэн, гагнуурчин нь автотээврийн хэрэгслийн бүх төрлийн хийц загвар, агрегат эд ангийг цахилгаан, хийн болон бусад төрлийн гагнуураар гагнах чадварыг эзэмшсэн байх бөгөөд тэдгээр нь эрхэлсэн ажлынхаа чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан, засвар, үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологи ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техник, стандарт болон бусад баримт бичгийг судалж мэдсэн, өндөр ур чадвар, дадлага туршлагатай байна.
- 9.3 Дэс дараалсан, хоорондоо холбоотой хоёр ажилбарын технологийн дараалал, чанарын шаардлагын тухай мэдээллийг тухайн мэргэжлийн ажилтан эзэмшсэн байна.

10 Авто үйлчилгээний мэдээллийн сан

- 10.1 Авто засвар, үйлчилгээ эрхлэгчид нь цахим мэдээллийн нэгдсэн санд тээврийн хэрэгсэлд хийж гүйцэтгэсэн засвар, үйлчилгээний мэдээллээ тухай бүрт үнэн зөв, бүрэн гүйцэд оруулдаг байна.
- 10.2 Мэдээллийн санг ашиглахад шаардагдах техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.
- 10.3 Засварын үйлчилгээ эрхлэгч нь автотээврийн хэрэгсэлд хийж гүйцэтгэсэн засвар, үйлчилгээдээ техникийн үзүүлэлт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгдөг байна. Баталгааг мэдээллийн санд заавал бүртгэн оруулна.
- 10.4 Тухайн ажлыг гүйцэтгэхэд мэдээллийн санг өргөн ашиглаж, үйлчлүүлэгчийн сонирхол, эрх ашгийг дээдэлсэн, сэтгэл ханамжийг татсан ажиллах орчин бүрдүүлсэн байна.

11. Зогсоол талбайд тавих шаардлага

- 11.1 Зогсоол талбай нь MNS5342:2007 стандарт, автотээврийн ажил, үйлчилгээ явуулах барилга байгууламж нь БНБД31-03-03, БНБД32-04-06 норм дүрмийн шаардлагын дагуу автомашин тавихад зориулж тэгшилж цардсан байна.
- 11.2 Автотээврийн ажил үйлчилгээ явуулах БНБД31-03-03, БНБД32-04-06 заасан норматив шаардлагын дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан автомашины болон явган хүний замтай байх;
- 11.3 Автотээврийн хэрэгсэл байрлах зогсоолын байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар тэмдэглэж, зориулалтын зогсоолоос бусад газарт автотээврийн хэрэгсэл байрлуулахыг хориглоно.